



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Энх амгалан өлзийт ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/109/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга: Г.Нандинжаргал
Утас: 7000-7734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn
Санхүүгийн аудитын албаны ахлах менежер: Х.Түвшинбаяр
Утас: 11315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Санхүүгийн аудитын албаны аудитын менежер: Я.Алтанцэцэг
Утас: 11315558 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn
Авера аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал: Г.Нарантуяа
Утас: 99133545 Цахим хаяг: avera.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

- 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ
- 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|--------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| НА | Нотлох ажил |
| НББОУС | Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ӨЭМТ | Өрхийн эрүүл мэндийн төв |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ЭМДҮЗ | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл |
| ЭМДЕГ | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар |
| ЭМДС | Эрүүл мэндийн даатгалын сан |
| НЭМГ | Нийслэлийн эрүүл мэндийн газар |
| НӨХГ | Нийслэлийн өмчийн харилцааны газар |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.03.13 № 706
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭНХ АМГАЛАН ӨЛЗИЙТ ӨЭМТ-ИЙН
ДАРГА Б.ОТГОНЗУЛ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Хан-Уул дүүргийн Энх амгалан өлзийт ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Нийслэлийн Хан-Уул дүүргийн Энх амгалан өлзийт ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 23.3 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн "толилуулга ба тодруулга", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, өдрийн эмчилгээ гэсэн 4 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Хашчагнуур ӨЭМТ нь нэг иргэнд ногдох болон 4 төрлийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлд Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээр 507.0 сая төгрөгийн санхүүжилт авч орлогын эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

С.Уснев/авалгаа /ОюуМорьиний хэргэ 2026.03.13/ 1426950066

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, иргэнд чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн шинэчлэл хийгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Энх амгалан өлзийт ӨЭМТ-ийн даргын 2025 оны Б/01 дүгээр тушаалаар бүтэц орон тоог 21-аар баталж, тайлант онд 16 орон тоогоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

2025 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/47 дугаар захирамжаар 88.7 хувь, ЭМДЕГ-аас эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний биелэлт 96.4 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2025.01.01. | 2025.12.31. |
|---------------|---|-----------------------|-----------------------|
| 1 | <u>ХӨРӨНГӨ</u> | | |
| 1.1.1 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | 970,048.34 | 7,086,896.02 |
| 1.1.4 | Бусад авлага | 31,302,393.76 | 6,167,712.60 |
| 1.1.6 | Бараа материал | 32,986,227.40 | 30,054,120.65 |
| 1.1 | Эргэлтийн хөрөнгийн дүн | 65,258,669.50 | 43,308,729.27 |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө (цэвэр) | 136,485,927.86 | 122,589,548.57 |
| 1.2.10 | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 136,485,927.86 | 122,589,548.57 |
| 1.3 | НИЙТ ХӨРӨНГӨ | 201,744,597.36 | 165,898,277.84 |
| 2.2 | Нийт өр төлбөр | - | - |
| 2.3 | <u>Эздийн өмч :</u> | | |
| 2.3.2 | -хувийн | 1,030,000.00 | 1,030,000.00 |
| 2.3.9 | Хуримтлагдсан үр дүн | 200,714,597.36 | 200,714,597.36 |
| | Тайлант үеийн | | (35,846,319.52) |
| 2.3.11 | Эздийн өмчийн дүн | 201,744,597.36 | 165,898,277.84 |
| 2.4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ | 201,744,597.36 | 165,898,277.84 |

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2025.01.01. | 2025.12.31. |
|---------------|---|-----------------------|------------------------|
| 1 | Борлуулалтын орлого | 451,345,810.61 | 481,736,264.50 |
| 2 | Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | - | - |
| 3 | Нийт ашиг | 451,345,810.61 | 481,736,264.50 |
| 5 | Хүүний орлого | 104,791.80 | 271,594.38 |
| 8 | Бусад орлого | 36,008,029.00 | 37,969,615.24 |
| 10 | Ерөнхий удирдлагын зардал | 483,012,690.24 | 555,823,793.64 |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | (9,823,740.78) | - |
| 18 | Татварын өмнөх ашиг (алдагдал) | (5,377,799.61) | (35,846,319.52) |
| 20 | Тайлант жилийн татварын дараах ашиг (алдагдал) | (5,377,799.61) | (35,846,319.52) |
| 24 | Орлогын нийт дүн | (5,377,799.61) | (35,846,319.52) |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2025.01.01. | 2024.12.31. |
|---------------|--|------------------------|-----------------------|
| 1 | 1.Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 1.1 | 1.1 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого | 450,233,756.65 | 512,161,261.78 |
| | Татаас санхүүжилтийн орлого | 450,058,964.85 | 507,419,845.66 |
| | Бусад орлого | 174,791.80 | 4,741,416.12 |
| 1.2 | 1.2 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага | 438,551,844.92 | 503,272,414.10 |
| | Ажиллагсдад төлсөн мөнгө | 325,609,368.00 | 369,092,392.00 |
| | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө | 36,970,995.34 | 43,805,461.89 |
| | Бараа материал худалдан авахад төлсөн | 48,158,821.90 | 41,820,424.00 |
| | Ашиглалтын зардалд төлсөн мөнгө | 1,639,500.00 | 1,914,168.00 |
| | Түлш шатахуун, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө | 2,911,020.00 | 10,162,610.00 |
| | Бусад мөнгөн зарлага | 23,262,139.68 | 36,477,358.21 |
| 1.3 | Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | 11,681,911.73 | 8,888,847.68 |
| 2 | 2.Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 2.2 | 2.2 Мөнгөн зарлагын дүн | 10,960,000.00 | 2,772,000.00 |
| | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө | 10,960,000.00 | 2,772,000.00 |
| 2.3 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | (10,960,000.00) | (2,772,000.00) |
| 3 | 3.Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 5 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | 721,911.73 | 6,116,847.68 |
| 6 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 248,136.61 | 970,048.34 |
| 7 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 970,048.34 | 7,086,896.02 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | Өмч | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг (алдагдал) | Нийт |
|----|---|---------------------|------------------------|-------------------------------------|---------------------------|-------------------------------|-----------------------|
| 1 | 2024 оны 01-р сарын 01-ээрх үлдэгдэл | 1,030,000.00 | | | | 200,714,597.36 | 201,744,597.36 |
| 2 | Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдаа | | | | | | - |
| 3 | Залруулагдсан үлдэгдэл | 1,030,000.00 | | - | | 200,714,597.36 | 201,744,597.36 |
| 4 | Тайлант хугацааны цэвэр ашиг (алдагдал) | - | | | | | |
| 8 | 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 1,030,000.00 | | - | - | 200,714,597.36 | 201,744,597.36 |
| 9 | Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдаа | - | | | | | - |
| 10 | Залруулагдсан үлдэгдэл | 1,030,000.00 | | - | - | 200,714,597.36 | 201,744,597.36 |
| 12 | Тайлант хугацааны цэвэр ашиг (алдагдал) | - | | | | (35,846,319.52) | (35,846,319.52) |
| 13 | Өмчид гарсан өөрчлөлт | | | | | | - |
| 14 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | | | | - | - |
| 15 | 2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 1,030,000.00 | - | - | - | 164,868,277.84 | 165,898,277.84 |

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 11,376.4 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулга хийлгэж баталгаажуулсан. Үүнд:

- Орлогын дэлгэрэнгүй тайлан, Мөнгөн гүйлгээний тайланд 4,469.8 мянган төгрөгөөр ангилал зөрүүтэй тайлагнасан;
- Мөнгөн гүйлгээний тайланд 6,906.6 мянган төгрөгийн зардлыг ангилал зөрүүтэй тайлагнасан алдааг залруулав.

Энэ нь НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 “Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх” болон санхүүгийн тайлагналын “*толилуулга ба тодруулга*”, “ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 23,330.6 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 23,330.6 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 23,330.6 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1.Үйл ажиллагааны зардлаас 16,000.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 03 тоот тогтоол " Өрх,сум,тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж,үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх,хяналт тавих журам"-ын 3.7-д "*Өрх,сум,тосгоны эрүүл мэндийн төвд хуваарилсан санхүүжилтийг зориулалт бус,хөтөлбөр,арга хэмжээнд зарцуулахыг хориглоно.*" заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;*" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бус зарцуулсан зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2.Ээлжийн амралтын тушаалд амрах хоног буруу оруулснаас 115.5 мянган төгрөгийг дутуу, 3,817.2 мянган төгрөгийн илүү олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 3.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”20 дугаар зүйлийн 20.2.5-д "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;*" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “толилуулга ба тодруулга”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Ээлжийн амралтын тушаалд амрах хоногийг буруу оруулж, ээлжийн амралтын олговрыг илүү, дутуу олгосон зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3. Гэрээт ажилтнуудад 2,881.2 мянган төгрөгийн ээлжийн амралтын хөлс олгосон байна. Энэ нь Энэ нь “Нөхөрлөлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5-д “Удирдах, төлөөлөх эрх бүхий гишүүдийн болон нөхөрлөлийн үйл ажиллагаанд бусад гишүүд хяналт тавина.”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Гэрээт ажилтнуудад ээлжийн амралт олгосон зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4. Илүү цагийн хөлсийг 137.9 мянган төгрөгөөр дутуу, 378.9 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “толилуулга ба тодруулга”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү цагийн хөлсийг холбогдох журмын дагуу тооцож олгоогүй, программд буруу татагдаж байгаа зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж буй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй болсон (79,691.8 мянган төгрөг) хөрөнгийн ашиглалтын хугацааг тухайн хөрөнгийн эдийн засгийн нас буюу эдийн засгийн өгөөжид үндэслэн тогтоож дахин үнэлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2-т “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох;” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “толилуулга ба тодруулга”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхөж үлдэх өртөггүй болсон хөрөнгийг дахин үнэлэх хүсэлтийг холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|--|------------|-----------------|-----------------------------------|----------|--------------------------|-----------------|------------|-----------------|--------------|----------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Орлогын дэлгэрэнгүй тайлан, Мөнгөн гүйлгээний тайланд 4,469.8 мянган төгрөгөөр ангилал зөрүүтэй тайлагнасан. | 1 | 4,469.8 | | | 1 | 4,469.8 | 1 | 4,469.8 | | |
| Мөнгөн гүйлгээний тайланд 6,906.6 мянган төгрөгийн зардлыг ангилал зөрүүтэй тайлагнасан | 1 | 6,906.6 | | | 1 | 6,906.6 | 1 | 6,906.6 | | |
| Дүн | 2 | 11,376.4 | 0 | 0 | 2 | 11,376.4 | 2 | 11,376.4 | 0 | 0 |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|-------------|-----------|---------------|-----|-----------------|-----------|---------|-----|--------------------------------------|---------------------|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо |
| Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй болсон (79,691.8 мянган төгрөг) хөрөнгийг дахин үнэлээгүй байна. | 1 | - | | | | | 1 | 0 | | |
| Үйл ажиллагааны зардлаас 16,000.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. | 1 | 16,000.00 | | | 1 | 16,000.00 | | - | | |
| Гэрээт ажилтнуудад 2,881.2 мянган төгрөгийн ээлжийн амралтын хөлс олгосон байна. | 1 | 2,881.20 | | | 1 | 2,881.20 | | | | |
| Илүү цагийн хөлсийг 137.9 мянган төгрөгөөр дутуу, 378.9 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна. | 1 | 516.8 | | | 1 | 516.80 | | | | |

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Энх амгалан өлзийт ӨЭМТ-ийн 2025 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

| | | | | | | | | | | |
|--|----------|-----------------|----------|----------|----------|-----------------|----------|----------|--|--|
| Ээлжийн амралтын тушаалд амрах хоног буруу оруулснаас 1 хүнд 115.5 мянган төгрөгийг дутуу, 9 хүнд 3,817.2 мянган төгрөгийн илүү олгосон байна. | 1 | 3,932.60 | | | 1 | 3,932.60 | | | | |
| Дүн | 5 | 23,330.6 | 0 | 0 | 4 | 23,330.6 | 1 | 0 | | |



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 406/Б.1000178

Улаанбаатар хот

НТТГ-2026/109/НН-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хан-Уул дүүргийн Энх амгалан өлзийт Өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үйл ажиллагааны зардлаас 16,000,000.00 (арван зургаан сая) төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 03 тоот тогтоол "Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх, хяналт тавих журам"-ын 3.7-д "Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд хуваарилсан санхүүжилтийг зориулалт бус, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" заасныг үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс зориулалт бус зарцуулсан зөрчлийг зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Хан-Уул дүүргийн Энх амгалан өлзийт Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Б.Отгонзул, нягтлан бодогч Д.Нямдорж нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АВЕРА АУДИТ ХХК-НИЙ ЗАХИРАЛ

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
Г.НАРАНТУЯА

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090757



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 405/Б.1000198

Улаанбаатар хот

НТАГ-2026/109/НА-СТН-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хан-Уул дүүргийн Энх амгалан өлзийт Өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гэрээт ажилтнуудад 2,881,200.00 (хоёр сая найман зуун наян нэгэн мянга хоёр зуун) төгрөгийн ээлжийн амралтын хөлс олгосон байна.

Энэ нь Нөхөрлөлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5-д "Удирдах, төлөөлөх эрх бүхий гишүүдийн болон нөхөрлөлийн үйл ажиллагаанд бусад гишүүд хяналт тавина", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Гэрээт ажилтнуудад ээлжийн амралтын цалин олгосон зөрчлийг зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Хан-Уул дүүргийн Энх амгалан өлзийт Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Б.Отгонзул, нягтлан бодогч Д.Нямдорж нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АВЕРА АУДИТ ХХК-НИЙ ЗАХИРАЛ

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
Г.НАРАНТУЯА

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090759



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар НОЧ/Б1000198

Улаанбаатар хот

НТАГ-2026/109/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хан-Уул дүүргийн Энх амгалан өлзийт Өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ээлжийн амралтын тушаалд амрах хоногийг буруу оруулснаас 1 хүнд 115,500.00 (нэг зуун арван таван мянга таван зуун) төгрөгийг дутуу, 9 хүнд 3,817,200.00 (гурван сая найман зуун арван долоон мянга хоёр зуун) төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 3.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Ээлжийн амралтын тушаалд амрах хоногийг буруу оруулж, ээлжийн амралтын олговрыг зөрүүтэй тооцож олгосон зөрчлийг зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Хан-Уул дүүргийн Энх амгалан өлзийт Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга В.Отгонзул, нягтлан бодогч Д.Нямдорж нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨТСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АВЕРА АУДИТ ХХК-НИЙ ЗАХИРАЛ

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
Г.НАРАНТУЯА

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426090767



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 403/Б1000178

Улаанбаатар хот

НТАГ-2026/109/НА-СТН-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хан-Уул дүүргийн Энх амгалан өлзийт Өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Илүү цагийн хөлсийг 137,900.00 (нэг зуун гучин долоон мянга есөн зуун) төгрөгөөр дутуу, 378,900.00 (гурван зуун далан найман мянга есөн зуун) төгрөгөөр илүү тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Илүү цагийн хөлсийг зөрүүтэй тооцож олгосон зөрчлийг зогсоож, биелэлтийг 2026 оны 9 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Хан-Уул дүүргийн Энх амгалан өлзийт Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Б.Отгонзул, нягтлан бодогч Д.Нямдорж нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АВЕРА АУДИТ ХХК-НИЙ ЗАХИРАЛ

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
Г.НАРАНТУЯА



Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426090769